



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/223

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн
данс бүртгэлд эргэлтийн бус
хөрөнгө бүртгэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу нийт 2,656,989.0 /хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга есөн зуун наян есөн/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянгол дүүргийн 13 дугаар сургууль /С.Энхтуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянгол дүүргийн 13 дугаар сургууль /С.Энхтуяа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦӨТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 08 өдрийн 0/223 дугаар тушаалын хавсралт



Хандив тусламжийн хөрөнгө бүртгэлд авах жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 13 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Агаар шүүгч	HEPA	КО8А	2019	сайн	ш	4	571,428.0	2,285,712.0	Нийслэлийн Байгаль орчны газар	Хандив
2	Өнгөт принтер	EPSON	L3110	2019	сайн	ш	1	371,277.0	371,277.0	Дэлхийн зөн ОУБ	Хандив
Нийт хөрөнгийн дүн									2,656,989.0		